



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА
Ц. ДУЛАМСҮРЭН ТАНАА

2018.02.26 № 06/537
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартад түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал төрийн аудитын байгууллага зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

Богд хаан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь гурвалсан гэрээг хийж, нөхөн сэргээх зардалд нийт 66,000.0 мянган төгрөгийг бэлэн ба бэлэн бусаар төвлөрүүлэхдээ авлага, өглөгийн тооцоо хийгээгүй, 10,000.0 мянган төгрөгийг 5070316039 тоот хугацаатай хадгамжинд нярав Н.Баярсайханы нэр дээр байршуулсан байна.

Үүрэг, хариуцлагын талаархи мэдээлэл

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ





БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор:** Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

naranchimegch@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 261740

Цахим хаяг:

gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор

Г.Жавхлан

Цахим хаяг:

javkhlang@audit.gov.mn

Дундманхайдай аудит ХХК

Захирал Ж.Бямбажав

Цахим хаяг:

dumaudit.mn

Байгууллагын хаяг:

Чингэлтэй дүүрэг

2-р хороо Төмөрчний гудамж

ТАБ-ын хаяг: Үндэсний
аудитын газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан



АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2018/696/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/107/СТА-ТШЗ аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 25-ны хооронд тус тус зохион байгуулан Дундманхайдай аудит ХХК-ийн аудитор Д.Уртнасан, туслах аудитор Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлэв.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд Дундманхайдай аудит ХХК-т ирүүлсэн байна.

Дундманхайдай аудит ХХК нь аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргад гардуулна.



Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн захирагч нь Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь Ойн сан бүхий газарт ойн хөнөөлт шавьжийн судалгааг хийлгэж, судалгаагаар тэмцэл хийх шаардлагатай газарт авиа биологийн аргаар тэмцлийн ажил хийлгэж, биелэлтэнд хяналт тавьж ажиллах, Богдхан уулын байгалийн унаган төрхийг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасныг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Богдхан уулын дархан цаазат тусгай хамгаалалттай газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитад Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилуудыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Санхүүгийн

тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол Улсын НББ-ийн стандартад нийцсэн Acolous 3.0 програмыг ашиглаж байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан үнэлж, гүйцэтгэлээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд дотоод хяналтын үйл ажиллагааг дундаж түвшинд байна гэж үзлээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төсвийн шууд захирагч нь 2017 оны жилийн эцсийн байдлаар төсөвт байгууллагын өөрийн орлогоор 69,728.0 мянган төгрөг, урсгал санхүүжилтээр 339,985.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 85,893.4 мянган төгрөгийн тус тус санхүүжилтийг авсан байна.


Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, 5 сая төгрөгөөс дээшхи гүйлгээг сар бүр мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 13 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Байгууллагын харилцах данс болон бэлэн мөнгөний дансны гүйлгээ, хөрөнгө, бараа материалын бүртгэл тооллого, тооцоо бодолт, өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, анхан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэргийг холбогдох хууль

тогтоомжийн заалтуудтай тулган баталгаажуулахад дараах эрсдэлүүд илэрсэн болно.

1.Гэрээт иргэд, аж ахуй нэгж байгууллагатай авлагын тооцоог хийж, бүрэн барагдуулаагүй, данс бүртгэл, санхүүгийн тайлан тэнцэлд тусгаагүй төдийгүй үйл ажиллагаандаа зарцуулсан,

2. ХУД-ийн Засаг дарга, БДЦГХЗ-ны дарга, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга нарын баталсан Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гурвалсан гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

Эдгээр асуудлуудыг Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд түүнийг шийдвэрлэсэн байдал хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 80 хувь, мөнгөн хөрөнгийн 90 хувь, нийт зардлын 40 хувь, нийт хөрөнгийн 50 хувийг тус тус эзэлж байна.


Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад байгууллагад илэрсэн зарим зөрчлийг шууд захирагчын анхааралд хандуулж байна. Эдгээр зөрчлийг захирал, нягтлан бодогч нартай зөвшилцөн санал солилцсон болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Үүнд:

1. Гэрээт иргэд, аж ахуй нэгж байгууллагатай авлагын тооцоог хийж, бүрэн барагдуулаагүй байна.

- Нөхөн сэргээх зардалд тооцон кассад бэлнээр хүлээн авсан 49728.0 мянган төгрөгийн орлогоос 28,900.0 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулан, санхүүгийн тайлан тэнцэлд тусгаагүй, үлдэгдэл 20,828.0 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй,
- Дээрхи үлдэгдлийн 10,000.0 мянган төгрөгийг 5070316039 тоот хугацаатай хадгаламжийн дансанд нярав Н.Баярсайханы нэр дээр байршуулсан, /10,780.0 мянган төгрөгийг Эрүүгийн цагдаагийн эдийн засагтай тэмцэх хэлтсээс битүүмжлэн хураан авсан./
- Эдгээр байгууллагатай авлага, өглөгийн тооцоо хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын

дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар 10,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 49,728.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайлан тэнцэлд тусган залруулсан ба зөрчил дутагдлыг цаашид дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөв.

2. ХУД-ийн Засаг дарга, БДЦГХЗ-ны дарга, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга нарын баталсан Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гурвалсан гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна. Үүнд:

- Гурвалсан гэрээг хийж, нөхөн сэргээх зардалд нийт 66,000.0 мянган төгрөгийг бэлэн ба бэлэн бусаар төвлөрүүлсэн, эдгээр байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо хийж, баталгаажуулаагүй,
- Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай 45 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг баталгаажуулж, гэрээний биелэлтийг тооцоогүй,
- 9 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийхдээ гэрээний дугаарыг давхардуулсан,
- Нөхөн сэргээх зардлын хэмжээг хэрхэн тооцох талаар журамд тодорхой заагаагүйгээс харилцан адилгүй хэмжээгээр 200.0-1000.0 мянган төгрөгөөр тооцон гэрээнд тусгасан,
- Гурвалсан гэрээ хийгдсэн 17 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын гэрээнд нөхөн сэргээх зардлыг төлөх талаар тусгаагүй,
- Түр журмын 3.1-д “ Иргэн, ААНБ-ын төслийг хэрэгжүүлэхдээ тухайн Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамжид 22500 төгрөг төлнө гэж заасны дагуу гэрээ хийгдсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас зөвхөн 23 иргэн гэрчилгээний үнэнд 495.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Дээрх Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журамд нөхөн сэргээх зардалд зарцуулах хөрөнгийн хэмжээг гэрээнд тусгахдаа хэрхэн тооцох талаар тодорхой заагаагүй, Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хуулийн 37 дугаар зүйл заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Аудитаар 495.0 мянган төгрөгийг санхүүгийн тайлан тэнцэлд тусган залруулсан ба цаашид гэрээний биелэлтийг тооцож, зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөв.

3. Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй байна.

- Үндсэн хөрөнгийн хөдлөл хөдөлгөөнийг илэрхийлэхдээ 495.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Санхүүгийн програмыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй, биет хөрөнгөөр бүртгэсэн,



- Мөнгөн кассын өдөр тутмын гүйлгээнд хөтлөгддөг анхан шатны баримтыг урьдчилан дугаарлан мөнгөн кассын няравт хүлээлгэж өгөөгүй байгаа нь үйл ажиллагааны орлого дутуу тусгагдах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх,” гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрхи зөрчил нь дараах хуулийн холбогдох заалтууд болон санхүүгийн тайлангийн толилуулгын батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна. Тухайлбал:

1. Иж бүрэн байх: “бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх”
2. Тохиолдсон байх: “байгууллагад хамаатай ажил гүйлгээ, үйл явдал тухайн хугацаанд тохиолдсон байх”
3. Үнэн зөв байдал: “ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцэж байх”

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй


Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

2017 оны 10 дугаар сараас эхлэн Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст тус газрын зарим үйл ажиллагааг шалгаж байгаа тул 2017 оны 1-10 дугаар сарын санхүүгийн анхан шатны баримтуудыг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад ХУД-ийн Засаг дарга, БДЦГХЗ-ны дарга, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга нарын баталсан Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай гурвалсан гэрээг хийж, нөхөн сэргээх зардалд нийт 66,000.0 мянган төгрөгийг бэлэн ба бэлэн бусаар төвлөрүүлжээ.

Дээрх гурвалсан гэрээ хийгдсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай гурвалсан гэрээг хийж, нөхөн сэргээх зардалд нийт 66,000.0 мянган төгрөгийг бэлэн ба бэлэн бусаар төвлөрүүлжээ.



Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 62,911.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 52,911.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өглөө. Төсөвт байгууллагын хувьд нийт зардлаар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзэн гүйцэтгэлийн шатанд дахин хянаж, нийт зардлын 1 хувиар буюу 5,552.4 мянган төгрөгөөр тогтоон илэрсэн зөрчил нь материаллаг байдлын түвшинг давсан тул хязгаарлалттай санал дүгнэлт өгөх санал оруулж байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны санхүүгийн тайланд Оюу эрдэм-Аудит ХХК аудит хийж, 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

Зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ЦЭДЭНБАЛЖИР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.УРТНАСАН





YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**Богдхан уулын дархан цаазат газрын
хамгаалалтын захиргааны 2017 оны
жилийн эцсийн санхүүгийн тайлан**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Гэрээний талаар 1

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Авлагын талаар 2

Асуудал 3

Мөнгөн хөрөнгө 3



Менежментийн захидал

Дундманхайдай-Аудит ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны удирдлага, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮАГ-ын ажиглалт

Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан түр журмыг үндэслэн ХУД-ийн Засаг дарга, БДЦГХЗ-ны дарга, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга нарын баталсан Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай 45 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний биелэлтийг тооцоогүй,

9 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийхдээ гэрээний дугаарыг давхардуулсан,

Нөхөн сэргээх зардлын хэмжээг хэрхэн тооцох талаар журамд тодорхой заагаагүйгээс харилцан адилгүй хэмжээгээр 200.0-1000.0 мянган төгрөгөөр тооцон гэрээнд тусгасан,

Гурвалсан гэрээ хийгдсэн 17 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын гэрээнд нөхөн сэргээх зардлыг төлөх талаар тусгаагүй,

Түр журмын 3.1-д “ Иргэн, ААНБ-ын төслийг хэрэгжүүлэхдээ тухайн Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамжид 22500 төгрөг төлнө гэж заасны дагуу гэрээ хийгдсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас зөвхөн 23 иргэн гэрчилгээний үнэнд 495.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль тогтоомж зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хуулийн 37 дугаар зүйл заалттай нийцүүлэн гурвалсан гэрээг шинэчлэх, гэрээний биелэлтийг тооцож байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх



Төсвийн Аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариуг танилцуулна

ҮАГ-ын ажиглалт

ХУД-ийн Засаг дарга, БДЦГХЗ-ны дарга, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга нарын баталсан Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай гурвалсан гэрээг хийж, нөхөн сэргээх зардалд нийт 66,000.0 мянган төгрөгийг бэлэн ба бэлэн бусаар төвлөрүүлжээ.

Дээрх гэрээний дагуу төвлөрүүлсэн дүнгээс бусад гурвалсан гэрээ хийгдсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоог хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайланг бэлтгэж гаргах” журмын дагуу бэлтгэж байх

Аж ахуйн нэгж байгууллагуудаас нөхөн сэргээх зардалд зарцуулах зорилгоор хүлээн авдаг орлогыг харилцах дансандаа төвлөрүүлэн өглөг, авлагын тооцоог хийж, баталгаажуулж, санхүүгийн тайлан тэнцэлд үнэн зөв илэрхийлж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Байгууллагын үйл ажиллагаанд хууль эрх зүйн актууд зөрчигдөх, санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх

Хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх

Төсвийн захирагчийн хариу
01 Төсвийн захирагчийн хариу
Аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн кассын өдөр тутмын гүйлгээнд хөтлөгддөг анхан шатны баримтыг урьдчилан дугаарлан мөнгөн кассын няравт хүлээлгэж өгөөгүй байгаа нь үйл ажиллагааны орлого дутуу тусгагдах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх,” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Байгууллагын үйл ажиллагаанд хууль эрх зүйн актууд зөрчигдөх, санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх

Хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх

ҮАГ-ын зөвлөмж


Мөнгөн кассын няравт хөтлөгдөх анхан шатны баримтуудыг бүрэн хөтөлж, хуулийн хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэж байх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтаа сайжруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчын хариу

Аудитаар өгсөн зөвлөмжийг

хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна




АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөг/

ДАНС	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,910,334.43	111,752,867.75
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	20,828,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	20,828,000.00
31110	Төгрөг	-	20,828,000.00
31120	Гадаад валют	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	-
31140	Арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	(0.00)
3121	Төгрөг	-	(0.00)
31211	Төрийн сангийн харилцах	-	(0.00)
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	67,910,334.43	90,924,867.75
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
35130	Эм боох материал	-	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	Хангамжийн материал	42,860,334.43	68,124,867.75
35410	Бичиг хэргийн материал	2,584,500.00	4,250,200.00
35420	Аж ахуйн материал	6,734,756.00	10,096,855.20
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш шатах тослох материал	221,500.00	3,843,500.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	33,319,578.43	49,934,312.55
35500	Биологийн хөрөнгө	24,450,000.00	22,100,000.00
35600	Мал, амьтад	600,000.00	700,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	420,631,211.73	405,036,272.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	420,631,211.73	405,036,272.27
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	420,631,211.73	405,036,272.27
39201	Барилга, байгууламж	438,572,304.30	429,780,954.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(109,894,786.86)	(120,653,448.18)
39203	Авто тээврийн хэрэгсэл	182,088,209.85	144,217,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(114,521,535.66)	(99,239,885.61)
39205	Машин, тоног төхөөрөмж	45,636,949.13	68,498,088.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,354,755.31)	(38,559,047.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,368,857.40	23,833,375.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,264,031.12)	(11,841,014.84)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-


39211	Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж	-	-
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,748,390.00	4,028,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,748,390.00)	(4,028,000.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Номын фонд	-	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	495,000.00	-
39302	Хасагдуулга	(495,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	-	-
39304	Хасагдуулга	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	488,541,546.16	516,789,140.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
41111	Бонд	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	488,541,546.16	516,789,140.02
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	461,573,092.36	461,573,092.36
51101	Өмч: -Төрийн өмч	461,573,092.36	461,573,092.36
51102	-Хувийн	-	-
51103	-Хувьцаат	-	-
51104	Халаасны хувьцаа	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	4,213,903.11	32,461,496.97
51210	Өмнөх үеийн үр дүн	4,213,903.11	4,213,903.11
51220	Тайлант үеийн үр дүн	-	28,247,593.86
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,754,550.69	22,754,550.69
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлтийн алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	488,541,546.16	516,789,140.02




АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	406,171,635.00	617,474,490.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,069,835.00	191,595,960.74
120	Нийтлэг татварын бус орлого	27,069,835.00	191,595,960.74
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	24,928,728.00	191,595,960.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,140.00	15,100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	49,728,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,928,588.00	126,767,960.74
120009	Бусад орлого	2,141,107.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,101,800.00	425,878,530.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	379,101,800.00	339,985,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	377,576,800.00	339,985,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,525,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	85,893,430.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	29,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	56,413,430.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	455,279,888.65	552,640,786.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,683,389.00	549,451,805.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,683,389.00	549,451,805.87
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	284,745,075.53	294,612,546.80
210101	Цалин	284,745,075.53	294,612,546.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,734,492.05	32,808,452.53
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,113,480.24	20,884,522.89
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,509,169.45	2,974,135.97
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,812,743.49	2,446,632.37
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	569,490.39	591,196.48
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,729,608.48	5,911,964.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,561,785.09	5,308,259.14
210301	Гэрэл цахилгааны зардал	1,627,400.00	2,126,110.60
210302	Түлш, халаалтын зардал	2,399,202.27	2,298,400.08
210303	Цэвэр, бохир усны зардал	710,182.82	883,748.46
210304	Байрны түрээс	825,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16,307,195.95	35,813,069.19
210401	Бичиг хэргийн материал	1,118,700.00	7,993,868.00
210402	Тээвэр, шатахууны зардал		




		7,884,537.46	10,868,611.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,012,738.49	1,737,263.71
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,459,600.00	2,536,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,831,620.00	-
210408	Бараа материал актасны зардал	-	12,677,226.48
2105	Нормативт зардал	600,000.00	24,113,575.35
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	24,113,575.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,527,000.00	1,180,000.00
210601	Багаж хэрэгсэл	18,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	720,000.00	-
210604	Урсгал засвар	788,500.00	1,180,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,057,000.00	9,924,000.00
210702	Дотоод томилолтын зардал	2,057,000.00	9,924,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	9,005,360.00	89,571,416.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,700,000.00	87,397,389.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	297,360.00	226,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,000.00	282,947.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,145,480.38	56,120,486.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,867,096.21	1,236,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,278,384.17	54,884,486.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,596,499.65	3,188,980.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,464,038.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,464,038.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,132,461.65	3,188,980.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,132,461.65	3,188,980.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(49,108,253.65)	64,833,704.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	36,586,110.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	28,536,110.19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	8,050,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(36,586,110.19)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(49,108,253.65)	28,247,593.86



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	397,576,940.00	495,606,530.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,000,140.00	69,728,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,000,140.00	69,728,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,000,140.00	69,728,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,140.00	20,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	49,728,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,576,800.00	425,878,530.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	377,576,800.00	339,985,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	377,576,800.00	339,985,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	85,893,430.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	29,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	56,413,430.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	397,576,940.00	474,778,530.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,576,940.00	474,778,530.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,980,440.35	461,100,049.18
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	286,019,102.74	284,387,115.77
210101	Үндсэн цалин	265,905,502.74	195,679,331.77
210102	Нэмэгдэл	-	54,740,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,113,600.00	18,015,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,000,000.00	15,952,284.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	31,636,454.03	32,544,383.56
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,214,395.11	22,062,008.41
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,310,216.59	2,183,154.72
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,924,007.50	2,649,744.93
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	492,933.37	513,588.68
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,694,901.46	5,135,886.82
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	7,080,785.09	6,280,259.14
210301	Гэрэл цахилгааны зардал	3,146,400.00	3,098,110.60
210302	Түлш, халаалтын зардал	2,399,202.27	2,298,400.08
210303	Цэвэр, бохир усны зардал	740,182.82	383,748.46
210304	Байрны түрээс	825,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	11,649,738.49	22,470,874.71
210401	Бичиг хэрэг	1,231,700.00	3,558,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,756,500.00	14,490,611.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		




		2,012,738.49	2,017,263.71
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	648,800.00	605,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,800,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	594,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	594,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,552,000.00	12,092,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	43,500.00	10,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	720,000.00	712,000.00
210604	Урсгал засвар	788,500.00	1,180,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,057,000.00	9,924,000.00
210702	Дотоод албан томилолт	2,057,000.00	9,924,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,385,360.00	91,571,416.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,080,000.00	89,397,389.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,360.00	226,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,000.00	282,947.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,236,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,236,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,596,499.65	13,678,480.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,464,038.00	10,489,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,464,038.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	10,489,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,132,461.65	3,188,980.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,132,461.65	3,188,980.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	20,828,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	20,828,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,828,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	58266,372.70	489,594,015.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	58266,372.70	489,594,015.75
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			49,108,253.65	49,108,253.65
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	4,213,903.11	488,541,546.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	4,213,903.11	488,541,546.16
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			7,419,593.86	7,419,593.86
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	11,633,496.97	495,961,140.02



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	447,678,530.00	442,689,549.18	4,988,980.82	98.89
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	447,678,530.00	442,689,549.18	4,988,980.82	98.89
210	Бараа, үйлчилгээний зардал	437,178,530.00	432,200,049.18	4,978,480.82	98.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,042,600.00	284,387,115.77	1,655,484.23	99.42
210101	Үндсэн цалин	196,294,600.00	195,679,331.77	615,268.23	99.69
210102	Нэмэгдэл	54,740,000.00	54,740,000.00	-	100.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	19,008,000.00	18,015,500.00	992,500.00	94.78
210105	Гэрээт ажлын хөлс	16,000,000.00	15,952,284.00	47,716.00	99.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,544,600.00	32,544,383.56	216.44	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,062,009.31	22,062,008.41	0.90	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,183,180.56	2,183,154.72	25.84	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	2,649,744.93	2,649,744.93	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,764.25	513,588.68	175.57	99.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,135,900.95	5,135,886.82	14.13	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,481,000.00	6,280,259.14	200,740.86	96.90
210301	Гэрэл цахилгаан	3,114,900.00	3,098,110.60	16,789.40	99.46
210302	Түлш, халаалт	2,376,100.00	2,298,400.08	77,699.92	96.73
210303	Цэвэр, бохир ус	990,000.00	883,748.46	106,251.54	89.27
2104	Хангамж, бараа материалын зардал	22,466,200.00	20,658,263.71	1,807,936.29	91.95
210401	Бичиг хэрэг	3,323,600.00	3,321,000.00	2,600.00	99.92
210402	Тээвэр (шатахуун)	12,917,100.00	12,915,000.00	2,100.00	99.98
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,019,600.00	2,017,263.71	2,336.29	99.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,205,900.00	2,405,000.00	1,800,900.00	57.18
2105	Нормативт зардал	594,000.00	594,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	594,000.00	594,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	12,102,800.00	12,092,000.00	10,800.00	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,202,000.00	10,200,000.00	2,000.00	99.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	712,800.00	712,000.00	800.00	99.89
210604	Урсгал засвар	1,188,000.00	1,180,000.00	8,000.00	99.33
2107	Томилолт, зочны зардал	9,933,800.00	9,924,000.00	9,800.00	99.90
210702	Дотоод албан томилолт	9,933,800.00	9,924,000.00	9,800.00	99.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	65,777,530.00	64,484,027.00	1,293,503.00	98.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,492,630.00	62,310,000.00	1,182,630.00	98.14
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,485,000.00	1,485,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	226,080.00		



				70,920.00	76.12
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,800.00	282,947.00	34,853.00	89.03
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	185,100.00	180,000.00	5,100.00	97.24
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,236,000.00	1,236,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,236,000.00	1,236,000.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,500,000.00	10,489,500.00	10,500.00	99.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,500,000.00	10,489,500.00	10,500.00	99.90
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,500,000.00	10,489,500.00	10,500.00	99.90
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	469,395,030.00	448,567,030.00	20,828,000.00	95.56
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	339,985,100.00	339,985,100.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	339,985,100.00	339,985,100.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	43,516,500.00	22,688,500.00	20,828,000.00	52.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,688,500.00	22,688,500.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,828,000.00	-	20,828,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,893,430.00	85,893,430.00	-	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,480,000.00	29,480,000.00	-	100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,413,430.00	56,413,430.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,828,000.00	(20,828,000.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35.00	35.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

